

БАТЛАВ. "ЯДУУ ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН
САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ



Н.ОЮУНЧИМЭГ

БАТЛАВ. "ГРИЙН ТРИЙ" КОМПАНИЙ
ЗАХИРАЛ



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2015 оны 01-р сарын 05-ны өдөр

№ ____

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээг нэг талаас Санхүүгийн Зохицуулах хороо, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3/9 G Mobile компаний 307 тоот хаягт (утас 311780) /цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас Хан-Уул дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөөний 25/74 хаягт байрлах 5907799 тоот регистрийн дугаартай, 9011518081 улсын бүртгэлийн дугаартай "Грийн трий" ХХК-ийг төлөөлж Захирал С.Даваасүрэн /цаашид "гүйцэтгэгч" гэх/, хамтад нь "талууд" гэх/ нар харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Үндсэн хууль, Зохиогчийн эрхийн хууль, бусад хууль тогтоомжуудыг үндэслэн байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго нь захиалагчийн өмч болох "Саятан болгох дамжаа" 35 минутын хугацаатай 24 ангит кино болон киноны бусад бүтээлүүдийг /цаашид "кино" гэх/ "Боловсрол суваг" телевизийн эфирээр нэвтрүүлэх, түүнчлэн киноны нээлтийн улаан хивсний ёслолын нэвтрүүлгийг бэлтгэх түүнийг цацахтай холбоотойгоор талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.3 Телевиз нь дараах бүтээлүүдийг олон нийтийн хүртээл болгоно. Үүнд:
 - 1.3.1 "Саятан болгох дамжаа" 24 ангит нийт үргэлжлэх хугацаа 840 минут бүхий киног ажлын өдрүүдэд 20:30 цагт эхлүүлж цацах ба дараа өдөр нь 10:00-15:00 цагийн хооронд давтан мөн амралтын өдрүүдэд тухайн 7 хоногийн нийт ангийг давтан гаргах.
 - 1.3.2 Кино бүтсэн түүх 40 минутын бэлэн нэвтрүүлгийг 20 минутаар 2 хувааж тус бүр 3 удаа цацах ба телевизийн батлагдсан хөтөлбөрийг урьдчилан ирүүлэх.
 - 1.3.3 Киноны трейлер 2 минут, 1 минут, 30 секунд тус бүрээр бэлдсэнийг кино цацагдахаас 7 хоногийн өмнөөс эхлэн кино дуусах хүртэлх бүхий л хугацаанд өдөрт 15 удаа цацна.
 - 1.3.4 4 минут 41 секундын хугацаатай киноны дууны клипийг кино цацагдахаас 7 хоногийн өмнөөс эхлэн кино дуусах хүртэлх бүхий л хугацаанд өдөрт 4 удаа цацна.
 - 1.3.5 Нээлтийн үйл ажиллагааны Улаан хивсний ёслолын 30 минутын нэвтрүүлэг бэлтгэж, 1 удаагийн давталттайгаар цацах ба телевизийн батлагдсан хөтөлбөрийг урьдчилан ирүүлэх..

Хуудсыг баталгаажуулсан

- 1.4 Энэхүү гэрээг Талууд 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 2015 оны 02 сарын 12-ний өдрийг дуустал хугацаатайгаар байгуулж байна. Гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө Талууд гэрээний үр дүнг хэлэлцээд сунгаж болох ба сунгах хугацааны талаар тухайн үед шийдвэрлэнэ.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь киног бусад телевиз, байгууллага, хувь хүнд төлбөртэй болон төлбөргүйгээр аливаа хэлбэрээр шилжүүлэхгүй /хадгалуулахгүй, хуулбарлахгүй/ байх үүрэгтэй.
- 2.2 Гүйцэтгэгч нь “Саятан болгох дамжаа” 24 ангит киног 2015 оны 01 сарын 12-ны өдрөөс эхлэн Даваа гарагаас Баасан гарагт 20:30 цагт шинэ анги, маргааш өглөө нь 10:00-15:00 цагийн хооронд давтан мөн амралтын өдрүүдэд өмнөх 7 хоногийн нийт ангийг давтаж "Боловсрол суваг" телевизээр нэвтрүүлэх үүрэгтэй.
- 2.3 Гүйцэтгэгч нь киноны дундуур нийт 8 минутаас хэтрэхгүй зар сурталчилгааны блокийг оруулна. Төгсгөлийн 45 минут үргэлжлэх ангид зар сурталчилгааны үргэлжлэх хугацаа нь 10 минутаас ихгүй байна.
- 2.4 Киноны үйл явдалтай уялдуулан, уг киногоор хүргэх гэж байгаа санхүүгийн боловсролын мессэж мэдээллийг төслийн хөндлөнгийн мониторинг үнэлгээний баг гар утасны мессэжээр авах тул гүйцэтгэгч нь хуваарьт цагийг чанд баримтлан цацалтыг хийнэ.
- 2.5 Захиалгчийн бэлтгэсэн санхүүгийн боловсролын судалгааны асуулга болон тухайн асуулгатай хамааралтай мессэж мэдээллээр кино цацагдаж байх хугацаанд титр явуулна.
- 2.6 Киноны нээлтийн улаан хивсний ёслолын арга хэмжээний хөтөлбөр зохиолыг боловсруулж, зураг авалт эвлүүлгийг хийж нэвтрүүлгийг бэлтгэж цацалтыг хийнэ.
- 2.7 Гүйцэтгэгч нь Улаан хивсний ёслолын танхимыг “Саятан болгох дамжаа” киноны нээлтэнд зориулж бэлтгэх ба түүнийг ашиглахтай холбоотой зардлыг хариуцана.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч нь гэрээний 1.2-д заасан бүтээлүүдийг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн HD форматаар эфирийн болон техникийн шаардлага хангасан байдлаар гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.2 Захиалагч нь киноны оюуны өмчийн болон зохиогчийн эрх, түүнтэй холбогдон гарах аливаа асуудлыг бүрэн хариуцна.
- 3.3 Захиалагч нь гүйцэтгэгчтэй тохирсон үнэ тариф болон гэрээний талаарх мэдээллийг холбогдох хуулийн хүрээнд мэдээлж тайлагнаж болно.
- 3.4 Захиалагч нь гэрээнд заасан ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах ялангуяа эфирийн цацалтын цагт хатуу хяналт тавьж, хуваарьт цагийг баримтлуулах эрхтэй.



Хуудсыг баталгаажуулсан

Дөрөв. Төлбөр тооцоо

- 4.1 Захиалагч нь гэрээний 1.2-т заасан бүтээлүүдийг “Боловсрол суваг” телевизийн эфирээр нэвтрүүлсний төлбөр болох 60,520,000 төгрөгийг “Грийнтри” ХХК-ийн “Хас” банкин дахь төгрөгийн 5001256602 тоот дансанд дараах нөхцөлийн дагуу шилжүүлнэ.

Төлбөрийн нөхцөл	Дүн	Холбогдох бичиг баримт
Гэрээ байгуулж, киноны трэйлер, клипний эхний цацалт хийгдэн, улаан хивсний ёслолын төлөвлөгөө гарсаны дараа	80% болох 48,416,000	Нэхэмжлэл болон ТВ-ийн батлагдсан хөтөлбөр, нээлтийн улаан хивсний ёслолын нэвтрүүлгийн дэлгэрэнгүй сцейнар
Нийт 24 ангит кино болон бусад бүтээлүүд цацагдаж дууссаны дараа	20% буюу 12,104,000	Нэхэмжлэл болон гэрээ дүгнэсэн акт

Тав. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол учруулсан хохирлоо буруутай тал нь нөхөн төлөх үүрэгтэй.
- 5.2 Талуудын харилцан тохиролцож бичгээр үйлдсэн гэрээг зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 5.3 Энэхүү гэрээний үүргээ аль нэг тал нь зөрчсөн тохиолдолд түүнээс гарах үр дагаварыг арилгахын тулд Талууд хамтран ажиллаж аль болох үр дүнд хүрэхийг эрмэлзэнэ.
- 5.4 Гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд уг маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эвийн журмаар эс шийдвэрлэж чадвал Монгол Улсын хуулийн дагуу Шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

Зургаа. Бусад нөхцөл

- 6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэн хоёр тал харилцан гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд хувиуд нэгэн адил хүчинтэй байна.
- 6.2 Хэрэв энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах болон шууд үгчилэн тусгагдаагүй бусад асуудлыг талууд урьдчилан харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэн, нэмэлт хавсралтад тусгана.

Гэрээ байгуулсан:

Захиалагчийг төлөөлж:

“Санхүүгийн үйлчилгээний
хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн

Төслийн зохицуулагч

Ц.Батбилэг

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Грийн-три” ХХК-ний

Захирал

С.Даваасүрэн

Хуудсыг баталгаажуулсан